Golomt Capital®

# ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.25

Golomt Capital®

# АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

**2022 оны 4-р сарын 25**

***Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:***

- ***АНУ-ын ам.долларын ханш хүчтэй байгаа нь алтны эрэлтэд сөргөөр нөлөөлж ханш нь сүүлийн хоёр долоо хоногийн хамгийн доод түвшиндээ хүрлээ. Алтны спот ханш 0.1 хувиар буурч, унц нь 1,928.08 ам.доллар болсон бол АНУ-ын алтны фьючерс 0.2 хувиар буурч 1930.10 ам.доллар болжээ.***

- ***Тодруулбал, АНУ-ын төв банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын хүрээнд бондын өгөөж нэмэгдэж ам.долларын ханш сүүлийн хоёр жилийн хамгийн дээд цэгтээ ирлээ.***

- ***Даваа гарагт АНУ-ын 10 жилийн хугацаатай бондын өгөөж дээд цэгтээ хүрч хөрөнгө оруулагчдын анхааралын төвд байна.***

- ***Холбооны Нөөцийн Сан 5 сард бодлогын хүүгээ хагас хувиар өсгөнө гэсэн хүлээлт байна. Мөн ирэх саруудад илүү өндөр хувиар хүүгээ нэмэгдүүлэх магадлалтай байгаа гэсэн мэдээлэл цацагдсаны дараа алтны ханш огцом уналаа.***

- ***Алт нь АНУ-ын богино хугацаат хүүгийн өсөлт болон өндөр өгөөжид мэдрэмтгий байдаг. Гэсэн ч эдийн засаг, улс төрийн хямралын үед үнэ цэнийн найдвартай хадгалалт гэж үздэг.***

- ***ОХУ-ын түрэмгийлэл гурав дахь сардаа үргэлжилж байна. Украины зүгээс АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Антони Блинкен, Батлан хамгаалахын сайд Лойд Аустин нарыг Киевд айлчлах үеэр илүү хүчирхэг зэвсэг хүсэх болно гэжээ.***

Golomt Capital®

# ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

**2022 оны 4 сарын 25**

***Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:***

- ***Шанхайд COVID-19-ийн халдварын улмаас тогтоосон хөл хорио, АНУ-ын бодлогын хүүгийн өсөлт нь газрын тосны эрэлтэд сөргөөр нөлөөлж буй тул даваа гарагт түүхий нефтийн ханш уналттай эхэллээ.***

- ***COVID-19-ийн дэгдэлттэй тэмцэж буй Шанхай хотын эрх баригчид орон сууцны барилгуудын гадна хашаа барьсан нь олон нийтийн эсэргүүцэлтэй тулж байна.***

- ***Брент нефтийн фьючерс 1.90 ам.доллар буюу 1.8 хувиар буурч, баррель нь 104.75 ам.доллар болсон бол АНУ-ын Баруун Техасын (WTI) нефтийн үнэ 1.89 ам.доллар буюу 1.9 хувиар буурч, баррель нь 100.18 ам.доллар болжээ.***

- ***Тавдугаар сарын сүүлээр АНУ-д зуны тээвэрлэлт эхлэхээс өмнө хөрөнгө оруулагчид газрын тос дээрх позицоо тодорхой болгохоор хичээж байна.***

- ***Украины хямрал гүнзгийрч, Европын холбоогоос Оросын нефтийг хориглох магадлалтай байгаа тул нефтийн үнэ нэг баррель нь 90 ам.доллараас буухгүй байна.***

- ***Нийлүүлэлтийн тал дээр АНУ-ын эрчим хүчний компаниуд газрын тос, байгалийн хийн цооногуудыг тав дахь долоо хоногтоо дараалан нэмжээ.***

- ***Европт Орос-Казахстаны Каспийн хоолойн консорциум байгууламжийнхаа нэгийг засварлаж 4 сарын 22-оос экспортоо бүрэн сэргээсэн байна.***

- ***Morgan Stanley Брент нефтийн үнийн төсөөллөө 10 ам.доллараар нэмэгдүүлж 130 ам.долларт хүргэсэн байна.***

***Мэдэгдэл:*** *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*